

Засгийн газрын 2019 оны 5 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД МӨНГӨН
УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ
Нэг. Нийтлэг зүйл

1.1. Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 51.1.4-т заасан мөнгөн урамшууллыг олгоход энэ журмыг мөрдөнө.

1.2. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараахь эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно:

1.2.1. төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;

1.2.2. төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид.

1.3. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг төсвийн байгууллага жил бүр төсөвтөө тусгана.

Хоёр. Төрийн албан хаагчид ажлын үр дүнгээр тооцон олгох

нийтлэг мөнгөн урамшуулал

2.1. Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.

2.2. Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна. *(Энэ заалтад Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)*

2.3. Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана.

2.4. Төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална.

2.5. Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно.

2.6. Төсвийн шууд захирагч энэ журамд нийцүүлэн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох нарийвчилсан журмыг баталж болно.

2.7. Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.

Гурав. Эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр

олгох мөнгөн урамшуулал

3.1. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд ажлын үр дүн, гүйцэтгэлийг нь үндэслэн мөнгөн урамшуулал олгоно. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага энэ журмын дагуу мөнгөн урамшуулал олгож болно.

3.2. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно. *(Энэ дэд заалтад Засгийн газрын 2019 оны 395 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)*

3.3. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгохдоо энэ журмын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэж, тухайн жилийн төсөвт уг урамшуулалд зориулан батлагдсан хөрөнгийн дүнд багтаан энэ журмын 3.10, 3.12-т заасан шийдвэрийг үндэслэн олгоно.

3.4. Мөнгөн урамшуулал олгоход дараахь шалгуур үзүүлэлтийг баримтална:

Албан тушаал	Үр дүнгийн үндсэн шалгуур	Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт
--------------	---------------------------	--

А.Эрүүл мэндийн ажилтанд тавигдах нийтлэг шалгуур үзүүлэлт		
Эрүүл мэндийн ажилтан	Үйлчилгээний чанар	1.Хүлээлгэж чирэгдүүлэлгүй үйлчилгээ үзүүлсэн байдал;
	Ажлын ачаалал, хариуцлага	1.Ажлын цаг ашиглалт;
	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	1.Эмчилгээ үйлчилгээнд шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн, эдийн засгийн үр өгөөжийг тооцсон байдал;
Б.Тусгай шалгуур үзүүлэлт		
Эмнэлгийн мэргэжилтэн	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар	1.Эмчилгээ, үйлчилгээний стандартыг мөрдөж байгаа байдал;
Эрүүл мэндийн бусад ажилтан	Хариуцсан ажлын чанар	1.Стандарт мөрдөж байгаа байдал;

3.5. Эрүүл мэндийн ажилтны албан тушаалын тодорхойлолтод тусгасан үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг дүгнэх журам, энэ журмын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалыг эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

3.6. Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг “бүрэн хангалттай”, “хангалттай” гэж үнэлж, улирал бүр дүгнэнэ.

3.7. Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараахь хувь хэмжээгээр сар бүр мөнгөн урамшуулал тооцно:

хувь	Бүх шалгуурын биелэлтийн	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Албан тушаалын үндсэн цалингаас урамшил тооцох хувь (сард)
90-100		Бүрэн хангалттай	11-20 хувь (Засгийн газрын 2019 оны 395 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)
71-89		хангалттай	10 хувь хүртэл

3.8. Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 71-ээс доош хувьтай байгаа тохиолдолд тухайн албан хаагчид улирлын урамшуулал олгохгүй.

3.9. Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг тухайн ажилтны ажиллаж байгаа тасаг, нэгжийн дарга үнэлж, хамт олны хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргана.

3.10. Эрүүл мэндийн байгууллагын тасаг, нэгжийн хамт олны хурлаас гаргасан дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшил олгох шийдвэрийг байгууллагын дарга гаргана.

3.11. Мөнгөн урамшууллыг дараа улирлын эхний сарын 15-ны дотор олгоно.

3.12. Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана.

Дөрөв.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын

сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах

багш, албан хаагчид олгох улирлын ажлын гүйцэтгэл,

үр дүнгийн мөнгөн урамшуулал

(Засгийн газрын 2022 оны 252 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

4.1.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага (цаашид “сургалтын байгууллага” гэх)-ын багш, туслах багш, албан хаагчид улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоно.

4.2.Энэ журмын 4.1-д заасан албан хаагч гэдэгт сургалтын байгууллагын төсвөөс цалинждаг орон тооны ажилтан хамаарна.

4.3.Мөнгөн урамшууллыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн гүйцэтгэлийн чанар, үр дүнг харгалзан ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгоно.

4.4.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшид мөнгөн урамшуулал олгоход энэ журмын 4.4.1, 4.4.2-т заасан шалгуур, үзүүлэлтийн дагуу ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж, уг урамшуулалд зориулан батлагдсан тухайн жилийн төсөвт багтаан олгоно.

4.4.1.цэцэрлэгийн багшид мөнгөн урамшуулал олгоход дараахь шалгуур, үзүүлэлтийг баримтална:

	Үр дүнгийн үндсэн шалгуур	Үр дүнгийн шалгуурыг тодорхойлох үзүүлэлт	Нийт оноо	4.4.2. ерөнхий боловсролын сургуулийн багшид мөнгөн урамшуулал олгоход дараахь шалгуур,
.		1.1.Хүүхдийн хөгжилд гарсан ахиц;		

	Үр дүнгийн үндсэн шалгуур	Үр дүнгийн шалгуурыг тодорхойлох үзүүлэлт	Нийт оноо
	Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагааны ахиц, үр дүн	1.2.Сургалтын орчинд эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартыг ханган ажилласан эсэх; 1.3.Хариуцсан бүлгийн хүүхэд хамгаалалтай холбоотой осол гэмтэл, зөрчил гарсан эсэх; 1.4.Хүүхдийн хөгжлийн ахиц, өөрчлөлт болон ялгаатай байдалд тохируулан сургалтын төлөвлөлтөд тохируулга хийж, хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг бүтээлчээр зохион байгуулж буй ажлын гүйцэтгэл.	60
	Багшийн мэргэжлийн хөгжлийн ахиц, үр дүн	2.1.Хувийн хөгжлийн төлөвлөгөөний (мэргэжлийн, мэргэшлийн, хувь хүний) төлөвлөлт, биелэлт, үр дүн; 2.2.Сургалт, үйл ажиллагааны дагуу үнэлгээ хийж, хөгжлийн ялгаатай байдлыг илрүүлсэн эсэх (шинжилгээ хийж, дүгнэлт гаргах); 2.3.Сургалт, үйл ажиллагааны дагуу хэрэглэгдэхүүн боловсруулж, ашигласан байдал; 2.4.Багшийн арга зүйн сан бүрдүүлж хичээл, хөгжүүлэх үйл ажиллагаанд хэрэглэсэн ажлын гүйцэтгэл, үр дүн; 2.5.Багшийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг дагаж, мөрдөж ажилладаг байдал; 2.6.Ажлын байранд мэргэжил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн бүлгээр хамтран суралцах, хөгжих үйл ажиллагаанд оролцсон байдал.	30
	Цэцэрлэгийн болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал, оруулсан хувь нэмэр	3.1.Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийнхээ хөгжлийг дэмжих чиглэлээр зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байдал; 3.2.Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр мэргэжлийн байгууллага, олон нийтийн дэмжлэгийг авч, хамтран ажилласан байдал.	10

	Үр дүнгийн үндсэн шалгуур	Үр дүнгийн шалгуурыг тодорхойлох үзүүлэлт	Нийт оноо
	Суралцагчид боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн	1.1.Хичээл сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, үр дүн; 1.2.Суралцагчийн сурлагын ахиц; 1.3.Сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт, үр дүн; 1.4.Сургалтын материал, нөөц, тохирох хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, баяжуулсан байдал, хэрэглээ.	5
	Суралцагчийг хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн	2.1.Сургуулийн орчинд суралцагчийг болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээ, түүний гүйцэтгэл, үр дүн; 2.2.Хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцооны талаар эцэг эх, асран хамгаалагчийг зөвлөгөө, мэдээллээр хангаж хамтран ажилласан арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн; 2.3.Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар суралцагч бүрийн онцлог хэрэгцээг харгалзан хөгжүүлж буй байдал, үр дүн (Дотуур байранд амьдарч байгаа суралцагч, ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн хөгжлийг дэмжихэд оруулсан хувь нэмрийг хамруулна).	0

	Багшийн мэргэжлийн хөгжлийн ахиц, үр дүн	3.1.Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн (мэргэжлийн, мэргэшлийн, хувь хүний) төлөвлөлт, биелэлт, үр дүн; 3.2.Багшийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, үг хэллэг, харилцаа, хандлага, үйлдлээр үлгэрлэн манлайлж буй байдал; 3.3.Ажлын байранд мэргэжил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн бүлгээр хамтран суралцах, хөгжих үйл ажиллагаанд оролцсон байдал; 3.4.Сургалт, үйл ажиллагаанд технологи ашиглах мэдлэг, ур чадвараа хөгжүүлж, бүтээлчээр ашиглаж буй байдал.	0	3
	Сургуулийн болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал, оруулсан хувь нэмэр	4.1.Сургуулиас зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсон байдал; 4.2.Багшийн ажлын үндсэн чиг үүргийн хүрээнд мэргэжлийн байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, олон нийттэй хамтран хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүн.		5

4.5.Энэ журмын 4.4.1, 4.4.2-т заасан шалгуур, үзүүлэлтийн дагуу багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх аргачлалыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.6.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн албан тушаалын сарын үндсэн цалингийн 25 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно. Улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн тооцох урамшууллын хэмжээг энэ журмын 4.5-д заасан аргачлалд тусгана.

4.7.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн туслах багшийн улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн мөнгөн урамшууллыг сарын үндсэн цалингийн 20 хүртэл хувиар сар бүр тооцож, улирал бүр олгоно.

4.8.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно.

4.9.Төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно.

4.10.Энэ журмын 4.1-д заасан багш, туслах багш, албан хаагчид улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын эрхлэгч, захирал гаргана.

4.11.Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана.

4.12.Боловсролын үнэлгээний байгууллага нь багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг хөндлөнгөөс үнэлэх үйл ажиллагааг зохион байгуулж, дүнг тайлагнах ажлыг хариуцна.

4.13.Ажлын гүйцэтгэл, үр дүн нь хангалтгүй үнэлэгдсэн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшид арга зүйн дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор мэргэжлийн хөгжлийн сургалт, үйл ажиллагаанд хамруулна.

-----o0o-----